163

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

Төвийн өргөн, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08
Цахим шуудан: info@cabinet.gov.mn
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2024.11.15 № ХЭГ/2243

Танай _____-ны №_____-т

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Ц.МӨНХТУЯА ТАНАА

Асуулгын хариу хүргүүлэх тухай

"Боловсролын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай" Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 326 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаар Монгол Улсын Ерөнхий сайдад тавьсан асуулгын хариуг Боловсролын сайдаас бэлтгэж ирүүлснийг Танд хүргүүлж байна.

Хүлээн авч, танилцана уу.

Хавсралт 02 хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА Н.УЧРАЛ

000245022989

164

МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛЫН САЙД

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Багa тойруу-44, Засгийн газрын III байр
Утас: 26-22-27, И-мэйл: info@moe.gov.mn
Вэб хаяг: moe.gov.mn

2024.11.08 № 1/2055

танай ____ -ны № ____ -т

МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН
ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН
ДАРГА Н.УЧРАЛ ТАНАА

Асуулгын хариу хүргүүлэх тухай

Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяагаас Монгол Засгийн газрын 2023 оны 326 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаар Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэд тавьсан асуулгатай танилцлаа.

Асуулгатай холбоотой тайлбар, мэдээллийг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт 7 хуудастай.

П.НАРАНБАЯР

14246 0934

Хавсралт.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяагаас
Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэд тавьсан асуулгын хариу

Нэг. Тогтоолын 1 дүгээр зүйлийн 1.1-т "Магадлан итгэмжлэгдсэн багш мэргэжлийн хөтөлбөрөөр суралцаж байгаа суралцагчдын сургалтын төлбөр, багш нарыг магистрын болон гадаад, дотоодод мэргэшүүлэх сургалтад суралцуулахад шаардагдах зардлыг 2024 оны төсвийн жилээс эхлэн төсвөөс санхүүжүүлэх талаар санал боловсруулж, зохих журмын дагуу Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх" даалгаврыг тухайн үеийн боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд өгсөн байна.

1.1. Энэ хүрээнд 2024 оны улсын төсөвт хэдэн төгрөг төсөвлөж, бакалавр болон магистрын түвшинд хэдэн суралцагчид хэрхэн зарцуулсан мэдээлэл:

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 103 дугаар тогтоол батлагдсанаас хойш өнөөдрийг хүртэл нийтдээ 1,379 суралцагчид 2.4 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон байна. 11 дүгээр сараас эхлэн 6,288 суралцагчдад 14.6 тэрбум төгрөгийн санхүүжилтийг журмын дагуу олгохоор төлөвлөөд байна.

Энэхүү тогтоолоор батлагдсан журамд 6 төрлийн шаардлага хангасан багш мэргэжлээр суралцагч болон багш, ажилтны хүүхдэд төрөөс дэмжлэг үзүүлэхээр заасан бөгөөд энэ чиглэл тус бүрээр олгосон дэмжлэг, санхүүжилтийн хувьд:

- Тус журмын 2.1.1 дэх хэсэгт заасан "Боловсролын ерөнхий хуулийн 12.2-т заасан ерөнхий боловсролын сургуулийн багш мэргэжлийн сонгон бүлгийн төгсөгч" гэсэн чиглэлээр 2024-2025 оны хичээлийн жилд суралцаж буй суралцагч одоогоор байхгүй бөгөөд журмыг боловсруулж байна.

- Журмын 2.1.2. дахь хэсэгт заасан "багш бэлтгэх бакалаврын сургалтын үндсэн хөтөлбөрөөр суралцагч;" чиглэлээр 2024 оны 1-9 дүгээр саруудад 657 суралцагчид 1.1 тэрбум төгрөгийн тэтгэлэг олгосон байна. 2024 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр 4,434 суралцагчид 9.1 тэрбум төгрөгийг олгохоор тооцож байна. Мөн Засгийн газрын 2022 оны 346 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан журмын 2.11 дэх заалтын дагуу багш мэргэжлээр өндөр оноотой суралцагчийн тэтгэлэгт үргэлжлүүлэн суралцаж буй 1,069 суралцагчид 1.7 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгохоор тооцсон бөгөөд сургуулиас ирүүлсэн нэхэмжлэлийн дагуу санхүүжүүлж байна.

- Журмын 2.1.3. дахь хэсэгт заасан "боловсролын чиглэлээр магистрын сургалтын үндсэн хөтөлбөрөөр суралцагч;" чиглэлээр 2024 оны 10 дугаар сарын байдлаар 19 суралцагчид 22.5 сая төгрөг олгосон ба 2024 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр 1,062 суралцагчид 2.2 тэрбум төгрөгийн санхүүжилт олгохоор тооцсон.

- Журмын 2.1.4. дэх хэсэгт заасан "Багшийн хөгжлийг дэмжих тухай хуулийн 8.3-т заасан хөдөө орон нутагт багш мэргэжлээр дадлагажигч;" чиглэлээр 2024 оны 10 дугаар сарын байдлаар 192 суралцагчид 154.7 сая төгрөг олгосон ба 2024 оны

хүлээгдэж буй гүйцэтгэлээр 265 суралцагчид 444.9 сая төгрөгийн санхүүжилт олгохоор тооцсон.

- Журмын 2.1.5. дахь хэсэгт заасан "Боловсролын ерөнхий хуулийн 12.10-д заасан орон нутагт мэргэжлээрээ ажиллах багш" чиглэлээр 2024 оны 10 дугаар сарын байдлаар 88 суралцагчид 155.4 сая төгрөг, 2024 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр нийт 736 суралцагчид 1.6 тэрбум төгрөгийн санхүүжилт олгохоор тооцсон.

- Журмын 2.1.6. дахь хэсэгт заасан "Боловсролын ерөнхий хуулийн 13.3.6-д заасан багш, ажилтны нэг хүүхэд" чиглэлээр 2024 оны 10 дугаар сарын байдлаар 233 суралцагчид 552.8 сая төгрөг олгосон ба 2024 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр 673 суралцагчид 2.7 тэрбум төгрөгийн санхүүжилт олгохоор тооцсон.

1.2. 2025 оны улсын төсөвт хэдэн төгрөг төсөвлөж, бакалавр болон магистрын түвшинд хэдэн суралцагчид хэрхэн зарцуулахаар төлөвлөж байгаа талаарх мэдээлэл:

Багш хөтөлбөр
Төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагад багш мэргэжлээр бакалавр, (01) чиглэлээр магистрын хөтөлбөрт 2024 оны гүйцэтгэл 4420 суралцагчийн 14.4 тэрбум төгрөг шаардлагатай. 2025 онд 4862 суралцагчид 17.1 тэрбум төгрөгийн санхүүжилт шаардлагатай байна.

Орон нутагт хийх багшлах дадлага
Төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагч хөдөө, орон нутагт багшлах дадлага гүйцэтгэх тохиолдолд тухайн сургуулийн нэг хичээлийн жилийн сургалтын төлбөрийн 30 хувьтай тэнцэх хэмжээний амьжиргааны тэтгэлэг зардал олгодог. 2024 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр 477 суралцагчид 1.2 тэрбум төгрөгийг олгохоор төлөвлөсөн байна. 2025 онд 525 суралцагчид 1.5 тэрбум төгрөгийн санхүүжилт шаардлагатай байна.

Сургалтын төлбөрийн, буцалтгүй тусламж тэтгэлэг
Суралцагчийн эцэг, эхийн аль нэг төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежид 15-аас доошгүй жил тасралтгүй багш мэргэжлээр ажилласан ажилтны хүүхдийг тэргүүлэх, эрэлттэй мэргэжлээр суралцахад төрөөс сургалтын төлбөрийн дэмжлэг олгодог. 2024 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр 673 суралцагчид 2.7 тэрбум төгрөгийг олгохоор төлөвлөсөн байна. 2025 онд 740 суралцагчид 3.2 тэрбум төгрөгийн санхүүжилт шаардлагатай талаар төсвийн төслийн саналд тусган хүргүүлсэн.

Хоёр. Тогтоолын 1 дүгээр зүйлийн 1.2-т "Багшийн хөгжлийг дэмжих тухай хуульд заасны дагуу багшийн хөгжлийг дэмжих төвүүдийг байгуулж, үйл ажиллагаа явуулахад шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг жил бүрийн төсвийн төсөлд тусгах" үүргийг тухайн үеийн боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд даалгасан байна.

2.1. Энэ хүрээнд 2024 онд улсын төсөвт хэдэн багшийн хөгжлийн төвүүдийг байгуулахаар тусгаж, үүнд хэдэн төгрөг зарцуулж байгаа талаарх мэдээлэл:

Боловсролын ерөнхий хуулийн 12 дугаар зүйлийн 12.11, 12.13 дахь хэсэг, Багшийн хөгжлийн тухай хуулийн 7 дугаар зүйлд үндэслэн Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны А/164 дүгээр тушаалаар Монгол Улсын Боловсролын их сургуулийг түшиглэн Багшийн хөгжлийг дэмжих үндэсний төв, Монгол Улсын Боловсролын их сургуулийн Архангай аймаг дахь Багшийн сургууль, Монгол Улсын Их сургуулийн Ховд аймаг дахь салбар сургууль, Монгол Улсын Их сургуулийн Дорнод аймаг дахь салбар сургуулийг тус тус түшиглэн Багшийн хөгжлийг дэмжих бүсийн төв байгуулж үйл ажиллагааг эхлүүлэх бэлтгэл хангаж байна.Энэ тушаалын хэрэгжилтийг ханган үүднээс Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны А/64 дүгээр тушаалаар багшийн мэргэжлийн хөгжлийн сургалт, үйл ажиллагааг холбогдох талуудтай хамтран зохион байгуулах чиг үүрэг бүхий Багшийн хөгжлийг дэмжих үндэсний төвийг байгуулах, үйл ажиллагааг эхлүүлэхэд шаардагдах зардал болох 150,807,614 төгрөгийг батлалсан.

2.2. Мөн 2025 оны улсын төсвийн төсөлд хэдэн багшийн хөгжлийн төвүүдийг байгуулахаар тусгаж, үүнд хэдэн төгрөг зарцуулахаар байгаа тухай мэдээлэл:

2025 онд Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны А/164 дүгээр тушаалаар байгуулагдсан Багшийн хөгжлийг дэмжих үндэсний төв болон Монгол Улсын Боловсролын их сургуулийн Архангай аймаг дахь Багшийн сургууль, Монгол Улсын Их сургуулийн Ховд аймаг дахь салбар сургууль, Монгол Улсын Их сургуулийн Дорнод аймаг дахь салбар сургуулийг тус тус түшиглэсэн Багшийн хөгжлийг дэмжих бүсийн төвийн санхүүжилтийг "Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилтны мэргэжлийн хөгжлийг дэмжих, мэргэжил дээшлүүлэх сургалт, үйл ажиллагааны журам"-ын хүрээнд сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн нэг суралцагчид ногдох хувьсах зардлын Багшийн хөгжил буюу мэргэжил дээшлүүлэх зардалд цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилтны хөгжих хэрэгцээнд суурилсан цахим платформд түшиглэн явуулах тусгай сургалт (1, 5, 10 жилийн сургалтаас бусад), бусад сургалт үйл ажиллагааны зардлаас шийдвэрлэхээр төлөвлөж байна.

Гурав. Тогтоолын төслийн 1 дүгээр зүйлийн 1.3-т "Багш бэлтгэх сургалтын хөтөлбөр, стандарт, холбогдох дүрэм, журмыг шинэчлэн боловсруулж, батлах" үүргийг тухайн үеийн боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд даалгасан байна. Энэ хүрээнд боловсруулж, батлуулсан багш бэлтгэх сургалтын хөтөлбөр, стандарт, холбогдох дүрэм, журмын талаарх мэдээлэл.

Дээд боловсролын тухай хуульд заасан захиргааны хэм хэмжээний актууд бүгд батлагдсан. Тухайлбал, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 253 дугаар тогтоолоор "Дээд боловсролын сургалтын байгууллагад тавих техникийн зохицуулалт" батлагдан хэрэгжиж эхэлсэн. Боловсрол, шинжлэх ухааны сайдын 03 дугаар сарын 20-ны өдрийн А/146 дугаар тушаалын хавсралтаар "Дээд боловсролын сургалтын байгууллагад мөрдөх мэргэжлийн чиглэл /хөтөлбөрийн нэр/, индекс шинэчлэн батлагдсан. Хавсралтад "01 Боловсрол" гэсэн ерөнхий чиглэлийн "0111 Боловсрол" төрөлжсөн чиглэлд холбогдох нарийвчилсан чиглэлд багш бэлтгэх хөтөлбөрүүд багтсан.

Түүнчлэн Кембрижийн их сургуулийн зөвлөх багтай хамтран Монгол Улсын Боловсролын их сургуулийн багш бэлтгэх хөтөлбөр, хэрэгжүүлж буй үйл ажиллагааны нөхцөл байдалд дүн шинжилгээ хийсний үндсэн дээр гарааны багшийн стандартын төслийг боловсруулж байна.

Дээд боловсролын тухай хуулийн 20 дугаар зүйлд заасны дагуу дээд боловсролын сургалтын байгууллага нь хөтөлбөрөө боловсруулж, байгууллагын Хөтөлбөрийн хорооны дүгнэлтийг үндэслэн, ректор баталгаажуулан хэрэгжүүлдэг. Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн "Нийтлэг шаардлага шинэчлэн батлах тухай" А/147 дугаар тушаал батлагдсан. Тушаалаар дээд боловсролын сургалтын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлага батлагдсан. Хууль, хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлагад нийцүүлэн багш бэлтгэдэг дээд боловсролын сургалтын байгууллагууд сургалтын хөтөлбөрөө шинэчлэх ажлыг эхлүүлсэн. Тухайлбал, Монгол Улсын Боловсролын их сургуулийн Багшийн сургуулийн бага ангийн багш бэлтгэх сургалтын хөтөлбөрүүд шинэчлэгдэн хэрэгжиж эхэлсэн.

Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны А/216 дугаар тушаалын дагуу "Дээд боловсролын сургалтын агуулгыг багц цагаар тооцох, багц цагийг дүйцүүлэх журам" батлагдан хэрэгжиж байна.

Дөрөв. Тогтоолын 3 дугаар зүйлд "Багшийг орон сууцны хөнгөлөлттэй зээлд хамруулах болон багш бүрийг компьютержуулах боломжийг судлан, төсөл, арга хэмжээний саналаа 2024 оноос үе шаттай хэрэгжүүлэхээр тооцож танилцуулахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Барилга, хот байгуулалтын сайд Ц.Даваасүрэн, Сангийн сайд Б.Жавхлан нарт тус тус даалгасугай" гэжээ.

4.1. Багшийг орон сууцны хөнгөлөлттэй зээлд хамруулах чиглэлээр ямар төсөл, арга хэмжээ боловсруулж, 2024 онд хэдэн багшийг хамруулж, 2025 онд хэдэн багшийг хамруулахаар төлөвлөж байгаа тухай мэдээлэл:

2024 оны 04 дүгээр сарын 19-ны өдөр батлагдсан Үндэсний баялгийн сангийн тухай хуульд "10.1.2.Хуримтлалын сан нь газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг одоо үеийн Монгол Улсын иргэн бүрд тэгш, шударга хүртээх зорилгоор иргэний эрүүл мэнд, боловсрол, орон сууцны зориулалтаар дэмжлэг үзүүлэх" зориулалттай байхаар хуульчилсан. Хуулийн хэрэгжилтийн хүрээнд багш нарын орон сууцны асуудлыг холбогдох байгууллагуудтай хамтран шийдвэрлэхээр төлөвлөж байна.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр" батлагдсан. Хөтөлбөрийн "2.1.1.1.Нийгмийн даатгалын тогтолцоог сайжруулж, иргэн бүрд хуримтлалын сан бүрдүүлж, эрүүл мэнд, боловсрол, орон сууцны зориулалтаар ашиглах, тэтгэврээ өвлүүлэх, урьдчилан ашиглах боломжийг бүрдүүлнэ" гэж заасан, мөн 2.4.1-д "Үндэсний баялгийн сан, төлбөрийн чадварт нийцсэн орон сууцжуулалт"-тай холбоотой зорилт туссан.
"Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө-ний төсөлд боловсролын салбараас тусгах


саналд "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн "2.2.3.3.Багшийн хөдөлмөрийн бүтээмжийг бодитоор үнэлж, багш, ажилчдын цалин, хөдөлмөрийн хөлсний хэмжээг төсөв, мөнгөний бодлоготой уялдуулан үе шаттайгаар нэмэгдүүлж, улсын дундаж хэмжээнд хүргэж, нийгмийн баталгааг хангана" гэсэн зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор "Багшийн орон сууцны нөхцөлийг сайжруулах арга хэмжээг холбогдох яамтай хамтран хэрэгжүүлнэ" гэж багш нарын орон сууцны нөхцөлийг сайжруулах чиглэлээр хамтран ажиллах саналаа Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлээд байна.

4.2. Багш бүрийг компьютержуулах чиглэлээр ямар арга хэмжээ авч хэрэгжүүлсэн тухай мэдээллийг төрийн өмчийн боловсролын сургалтын байгууллага тус бүрээр гаргаж, хангалтын хувь (хэдэн багштайгаас хэдэн багшид олгогдсоныг), компьютерын марк, хүчин чадлын үзүүлэлтийг дэлгэрэнгүй хүснэгт ирүүлэх:

Боловсрол, шинжлэх ухааны яам /хуучин нэрээр/-аас 2023-2024 оны статистик мэдээллээр төрийн өмчийн нийт 32,483 багшаас 13,059 багш огт компьютергүй гэсэн судалгаа гарсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сараас 07 дугаар сарын хооронд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 14,905 ширхэг зөөврийн компьютер /Chromebook/ холбогдох хууль журмын дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулж компьютергүй багш нарт хуваарилсан.

Тоног төхөөрөмж	Техникийн тодорхойлолт	
Зөөврийн компьютер /Chromeboook /	Үйлдлийн систем	Chrome OS
	CPU	Intel® Celeron™ N4000 1.1 ~ 2.6Ghz (Dual Core) болон түүнээс дээш
	Дэлгэцийн хэмжээ	15.6 инч FHD LED Display
	Дэлгэцийн нягтрал	FHD (1920 x 1080)
	График карт	Intel® UHD Graphics 600
	RAM-шуурхай санах ой	4GB LPDDR4 (2400MT/s) болон түүнээс дээш
	ROM-дотоод санах ой	64GB болон түүнээс дээш
	Хард-ны төрөл	eMMc
	Камер	720p HD Camera
	Чанга яригч	Stereo Speakers (1.5 W x 2)
	Wireless Сүлжээ	802.11 ac wave2 2X2
	Bluetooth®	Bluetooth 4.0
	Оролт	1*USB 2.0, 2*USB-C, 1 x Micro SD Card Slot (Capacity up to 2TB)
	Microphone	Байна
	Батарей	39Wh (5070mAh)
	Дагалдах хэрэгсэл	100-240V AC 50/60Hz цэнэглэгч, Баталгааны хуудас
	Баталгаат хугацаа	12 сар

2024 оны 6 дугаар сарын байдлаар багш бүрийг компьютероор хангаж явц дараах байдалтай байна.



№	Аймаг	Төрийн өмчийн ЕБС ийн багшийн тоо	компьютержүүлсэн багшийн тоо	Шийдвэрлэсэн нь	Үлдэгдэл
1	Архангай	1056	71	71	Бүрэн шийдвэрлэгдсэн
2	Баян-Өлгий	1763	1248	1248	Бүрэн шийдвэрлэгдсэн
3	Баянхонгор	984	413	544	Бүрэн шийдвэрлэгдсэн
4	Булган	679	213	300	Бүрэн шийдвэрлэгдсэн
5	Говь-Алтай	861	20	20	Бүрэн шийдвэрлэгдсэн
6	Говьсүмбэр	210	6	6	Бүрэн шийдвэрлэгдсэн
7	Дархан-Уул	1009	330	330	Бүрэн шийдвэрлэгдсэн
8	Дорноговь	733	138	138	Бүрэн шийдвэрлэгдсэн
9	Дорнод	864	476	476	Бүрэн шийдвэрлэгдсэн
10	Дундговь	545	261	266	Бүрэн шийдвэрлэгдсэн
11	Завхан	982	568	568	Бүрэн шийдвэрлэгдсэн
12	Орхон	1101	35	35	Бүрэн шийдвэрлэгдсэн
13	Өвөрхангай	1349	757	758	Бүрэн шийдвэрлэгдсэн
14	Өмнөговь	851	19	19	Бүрэн шийдвэрлэгдсэн
15	Сүхбаатар	710	151	151	Бүрэн шийдвэрлэгдсэн
16	Сэлэнгэ	1123	713	713	Бүрэн шийдвэрлэгдсэн
17	Төв	899	110	148	Бүрэн шийдвэрлэгдсэн
18	Увс	1044	450	484	Бүрэн шийдвэрлэгдсэн
19	Ховд	1124	211	211	Бүрэн шийдвэрлэгдсэн
20	Хөвсгөл	1675	64	64	Бүрэн шийдвэрлэгдсэн
21	Хэнтий	893	5	5	Бүрэн шийдвэрлэгдсэн
23	Чингэлтэй	1127	760	760	Бүрэн шийдвэрлэгдсэн
24	Хан-Уул	1535	1128	1128	Бүрэн шийдвэрлэгдсэн
25	Сүхбаатар	1301	982	982	Бүрэн шийдвэрлэгдсэн
26	Сонгинохайрхан	2350	647	2120	Бүрэн шийдвэрлэгдсэн
27	Баянгол	2138	1237	2507	Бүрэн шийдвэрлэгдсэн
28	Баянзүрх	2876	1614	421	1193
29	Багаханга й, Багануур, Налайх	701	432	432	Бүрэн шийдвэрлэгдсэн
	НИЙТ орон нутаг	**20455**	**6259**	**6555**	**Бүрэн шийдвэрлэгдсэн**
	НИЙТ Улаанбаатар	**12028**	**6800**	**8350**	**1193**
	НИЙТ улсын хэмжээнд	**32,483**	**13,059**	**14,905**	**1,193**

Тав. Тогтоолын 4 дүгээр зүйлд "Төрийн өмчийн багш бэлтгэх их сургуулийн хичээлийн болон дотуур байрыг шинээр барих, өргөтгөх, сургалтын тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, хэрэглэгдэхүүнийг шинэчлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг тооцож Монгол Улсын 2024 оны төсвийн төсөлд тусгах арга хэмжээ авахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Сангийн сайд Б.Жавхлан нарт тус тус даалгасугай" гэжээ. 2024 оны төсөвт Төрийн өмчийн багш бэлтгэх их сургуулийн хичээлийн болон дотуур байрыг шинээр барих, өргөтгөх, сургалтын тоног төхөөрөмж, техник хэрэгсэл,

хэрэглэгдэхүүнийг шинэчлэхэд хэдэн төгрөг тусган, хэрхэн хэрэгжүүлж байгаа тухай мэдээлэл:

Төрийн өмчийн багш бэлтгэх их сургууль болох Монгол Улсын Боловсролын их сургуулиас ирүүлсэн саналыг үндэслэн тогтоолд заасан зардлыг 2024 оны төсвийн төсөлд тусган Сангийн яаманд хүргүүлсэн боловч 2024 оны төсөвт батлагдаагүй.

2024 оны батлагдсан төсвийн хүрээнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар дээд боловсролын салбартай холбоотой 115.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 6 төсөл арга хэмжээ хуулийн хүрээнд хэрэгжиж байна. Үүнээс төрийн өмчийн Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургуулийн харьяа эмч, сувилагч бэлтгэх салбар эмнэлгийн барилга Дорноговь, Дархан-Уул, Нийслэлд хэрэгжиж байна. Мөн Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуулийн хичээлийн байрын буулгалтын ажил бүрэн хэрэгжиж, газар шорооны ажил хийгдэж байна.